



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 8/88

Дадал сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 1.6.6 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор олон нийтийг хамарсан тэмдэглэлт өдөр, зөвлөгөөн, чуулган, баяр ёслолын үйл ажиллагааны хүрээнд “Нутгийн хөгжилд-Эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт эмэгтэйчүүдийн 17 дугаар чуулга уулзалтын шагналын зардал болон мэдээллийн самбарын материалын зардал тус тус гаргасугай.

2.Шагналын зардал 500,000 (Таван зуун мянга) төгрөг, мэдээллийн самбарын зардал 100,000 (Нэг зуун мянга) төгрөг, нийт зардлын 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000255